



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР ТӨҮГ-ЫН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/31/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот  
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Г.Гүнжидмаа  
Утас: 99998341 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn  
Аудитор С.Алтанхуяг  
Утас: 80104949 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn  
Гэрээгээр гүйцэтгэсэн:  
Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн  
Захирал Г.Энхтөр  
Утас: 80281690, 99032916 Цахим хаяг: ij17.audit@gmail.com

**Агуулга**

|   |    |
|---|----|
| 1. Аудитын санал дүгнэлт .....  | 3  |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....                                   | 5  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                          | 5  |
| 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....                         | 6  |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....                          | 7  |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                           | 8  |
| 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....      | 9  |
| 3. Аудитын тайлан .....   | 10 |
| 3.1 Ерөнхий зүйл .....  | 10 |
| 3.2 Дотоод хяналт .....   | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                           | 10 |
| 3.4 Материаллаг байдал .....  | 11 |
| 4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....                                  | 11 |
| 4.1 Байгууллагын үйл ажилагаа .....                                       | 11 |
| 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....            | 11 |
| 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....                                | 12 |
| 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 13 |
| 5.1 Шилэн дансны мэдээлэл .....   | 14 |
| 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....               | 14 |
| 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                              | 14 |
| 8. Аудитын илрүүлэлт .....  | 14 |
| 8.1 Залруулсан алдаа .....  | 14 |
| 8.2 Төлбөрийн акт .....   | 15 |
| 8.3 Зөвлөмж .....   | 15 |
| 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....                         | 17 |

### Товчилсон үгийн жагсаалт

|        |   |
|--------|---|
| ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар         |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НД     | Нийгмийн даатгал                              |
| НДШ    | Нийгмийн даатгалын шимтгэл                    |
| НӨАТ   | Нэмэгдсэн өртгийн албан татвар                |
| СТОУС  | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт    |
| ТУЗ    | Төлөөлөн удирдах зөвлөл                       |
| ТӨҮГ   | Төрийн өмчит үйлдвэрийн газар                 |
| ХХОАТ  | Хувь хүний орлогын албан татвар               |



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР  
ТӨҮГ-ЫН ДАРГА Б.ОТГОНБАЯР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/526  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон зүйл

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ нь Засгийн газрын ордонд байрладаг бөгөөд Ковид-19 цар тахалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас арга хэмжээг авч орон даяар хөл хорио тогтоосны улмаас 2021 оны 2 болон 4 дүгээр саруудад үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

#### Бусад асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт хэвлэмэл бүтээгдэхүүний зардлыг багасгах цахим үйлчилгээг нэвтрүүлэхээр тусгасан нь төрийн байгууллагуудын захиалах албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн болон хэвлэлийн бүтээгдэхүүн эрс буурч байна.

## Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 80 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн “Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын талаар авах арга хэмжээний тухай” 11 тоот тогтоолоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ыг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын харьяанд шилжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

| №               | Үзүүлэлт                                | /төгрөгөөр/            |                        |
|-----------------|---|------------------------|------------------------|
|                 |   | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
| <b>1</b>        | <b>ХӨРӨНГӨ</b>                          |                        |                        |
| <b>1.1</b>      | <b>Эргэлтийн хөрөнгө</b>                |                        |                        |
| 1.1.1           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө         | 242,648,883.51         | 285,882,539.55         |
| 1.1.2           | Дансны авлага                           | 27,209,806.00          | 31,071,096.40          |
| 1.1.6           | Бараа материал                          | 47,584,909.04          | 75,890,306.91          |
| <b>1.1.11</b>   | <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>          | <b>317,443,598.55</b>  | <b>392,843,942.86</b>  |
| <b>1.2</b>      | <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>            |                        |                        |
| 1.2.1           | Үндсэн хөрөнгө                          | 392,202,772.48         | 120,409,331.28         |
| 1.2.2           | Биет бус хөрөнгө                        | 32,832,531.84          | 18,040,483.58          |
| <b>1.2.10</b>   | <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>      | <b>425,035,304.32</b>  | <b>138,449,814.86</b>  |
| <b>1.3</b>      | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>               | <b>742,478,902.87</b>  | <b>531,293,757.72</b>  |
| <b>2</b>        | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>          |                        |                        |
| <b>2.1</b>      | <b>Өр төлбөр</b>                        |                        |                        |
| <b>2.1.1</b>    | <b>Богино хугацаат өр төлбөр</b>        |                        |                        |
| 2.1.1.1         | Дансны өглөг                            | 157,350.00             | 1,600,000.00           |
| 2.1.1.3         | Татварын өр                             | 4,302,965.77           | 6,270,929.42           |
| 2.1.1.8         | Урьдчилж орсон орлого                   | 15,065,032.80          | 11,936,451.81          |
| <b>2.1.1.13</b> | <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b> | <b>19,525,348.57</b>   | <b>19,807,381.23</b>   |
| <b>2.1.2</b>    | <b>Урт хугацаат өр төлбөр</b>           |                        |                        |
| <b>2.1.2.6</b>  | <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>    | -                      | -                      |
| <b>2.2</b>      | <b>Өр төлбөрийн нийт дүн</b>            | <b>19,525,348.57</b>   | <b>19,807,381.23</b>   |
| <b>2.3</b>      | <b>Эздийн өмч</b>                       |                        |                        |
| 2.3.1           | Өмч: төрийн                             | 47,942,966.07          | 47,942,966.07          |
| 2.3.6           | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл     | 11,078,269.00          | 11,078,269.00          |
| 2.3.8           | Эздийн өмчийн бусад хэсэг               | 319,150,000.00         | 319,150,000.00         |
| 2.3.9           | Хуримтлагдсан ашиг                      | 344,782,319.23         | 133,315,141.42         |
| 2.3.9.1         | Тайлангийн үеийн ашиг / алдагдал /      | 11,403,737.55          | 10,846,094.82          |
| 2.3.9.2         | Өмнөх үеийн ашиг / алдагдал /           | 333,378,581.68         | <b>122,469,046.60</b>  |
| <b>2.3.11</b>   | <b>Эздийн өмчийн дүн</b>                | <b>722,953,554.30</b>  | <b>511,486,376.49</b>  |
| <b>2.4</b>      | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>   | <b>742,478,902.87</b>  | <b>531,293,757.72</b>  |

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

/төгрөгөөр/

| <b>№</b>  | <b>Үзүүлэлт</b>                              | <b>2020 оны 12-р сарын 31</b> | <b>2021 оны 12-р сарын 31</b> |
|-----------|--|-------------------------------|-------------------------------|
| <b>1</b>  | <b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>           | <b>693,764,072.93</b>         | <b>598,695,740.89</b>         |
| 2         | Борлуулалтын өртөг                           | 599,255,177.71                | 514,822,861.44                |
| <b>3</b>  | <b>Нийт ашиг (алдагдал)</b>                  | <b>94,508,895.22</b>          | <b>83,872,879.45</b>          |
| 4         | Хүүний орлого                                | 1,810,419.26                  |                               |
| 5         | Ерөнхий ба удирдлагын зардал                 | 72,570,486.87                 | 52,812,696.06                 |
| 6         | Бусад зардал                                 | 11,078,008.11                 | 19,008,967.48                 |
| <b>7</b>  | <b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b> | <b>12,670,819.50</b>          | <b>12,051,215.91</b>          |
| 8         | Орлогын татварын зардал                      | 1,267,081.95                  | 1,205,121.09                  |
| <b>9</b>  | <b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>       | <b>11,403,737.55</b>          | <b>10,846,094.82</b>          |
| <b>10</b> | <b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>   | <b>11,403,737.55</b>          | <b>10,846,094.82</b>          |
| <b>11</b> | <b>Орлогын нийт дүн</b>                      | <b>11,403,737.55</b>          | <b>10,846,094.82</b>          |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| №  | ҮЗҮҮЛЭЛТ                                       | Өмч                  | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг    | 2021 оны 12-р сарын 31 |
|----|--|----------------------|-------------------------------------|---------------------------|-----------------------|------------------------|
| 1  | <b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>     | <b>47,942,966.07</b> | <b>11,078,269.00</b>                | <b>319,150,000.00</b>     | <b>333,378,581.68</b> | <b>711,549,816.75</b>  |
| 2  | НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга   |                      |                                     |                           | -                     | -                      |
| 3  | <b>Залруулсан үлдэгдэл</b>                     | <b>47,942,966.07</b> | <b>11,078,269.00</b>                | <b>319,150,000.00</b>     | <b>333,378,581.68</b> | <b>711,549,816.75</b>  |
| 4  | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)            |                      |                                     |                           | 11,403,737.55         | <b>11,403,737.55</b>   |
| 9  | <b>2020 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл</b> | <b>47,942,966.07</b> | <b>11,078,269.00</b>                | <b>319,150,000.00</b>     | <b>344,782,319.23</b> | <b>722,953,554.30</b>  |
| 10 | НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга   |                      |                                     |                           | (222,313,272.63)      | (222,313,272.63)       |
| 11 | <b>Залруулсан үлдэгдэл</b>                     | <b>47,942,966.07</b> | <b>11,078,269.00</b>                | <b>319,150,000.00</b>     | <b>122,469,046.60</b> | <b>500,640,281.67</b>  |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)            |                      |                                     |                           | 10,846,094.82         | <b>10,846,094.82</b>   |
| 17 | <b>2021 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл</b> | <b>47,942,966.07</b> | <b>11,078,269.00</b>                | <b>319,150,000.00</b>     | <b>133,315,141.42</b> | <b>511,486,376.49</b>  |



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

|            | ҮЗҮҮЛЭЛТ  | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|------------|---|------------------------|------------------------|
| <b>1</b>   | <b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                          |                        |                        |
| <b>1.1</b> | <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>   | <b>795,563,686.00</b>  | <b>674,834,842.80</b>  |
|            | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого                          | 795,563,686.00         | 674,834,842.80         |
| <b>1.2</b> | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>  | <b>656,408,932.62</b>  | <b>629,378,186.76</b>  |
|            | Ажиллагчдад төлсөн  | 188,904,447.61         | 165,178,216.64         |
|            | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн                                | 53,135,933.09          | 48,726,573.86          |
|            | Бараа материал худалдан авахад төлсөн                                 | 324,408,630.82         | 354,626,410.96         |
|            | Татварын байгууллагад төлсөн  | 65,338,760.99          | 46,328,555.21          |
|            | Бусад мөнгөн зарлага  | 24,621,160.11          | 14,518,430.09          |
| <b>1.3</b> | <b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>             | <b>139,154,753.38</b>  | <b>45,456,656.04</b>   |
| <b>2</b>   | <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>              |                        |                        |
| <b>2.1</b> | <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>   | <b>1,810,419.26</b>    | <b>-</b>               |
|            | Хүлээн авсан хүүний орлого  | 1,810,419.26           |                        |
| <b>2.2</b> | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>  | <b>41,326,500.00</b>   | <b>2,223,000.00</b>    |
|            | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                                   | 41,326,500.00          | 2,223,000.00           |
| <b>2.3</b> | <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b> | <b>(39,516,080.74)</b> | <b>(2,223,000.00)</b>  |
| <b>3</b>   | <b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                      |                        |                        |
| <b>3.1</b> | <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>   | <b>-</b>               | <b>-</b>               |
| <b>3.2</b> | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>  | <b>-</b>               | <b>-</b>               |
| <b>3.3</b> | <b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>         | <b>-</b>               | <b>-</b>               |
| <b>4</b>   | <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                                       | <b>99,638,672.64</b>   | <b>43,233,656.04</b>   |
| <b>5</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>               | <b>143,010,210.87</b>  | <b>242,648,883.51</b>  |
| <b>6</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>              | <b>242,648,883.51</b>  | <b>285,882,539.55</b>  |

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт                | 2020 оны гүйцэтгэл | 2021 оны         |                 |                   |       |
|---|--|--------------------|------------------|-----------------|-------------------|-------|
|   |  |                    | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл       | Зөрүү             | Хувь  |
| 1 | <b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>           | 693,764.1          | 593,700.0        | 598,695.7       | 4,995.7           | 100.8 |
| 2 | Борлуулалтын өртөг                           | 682,903.7          | 489,627.5        | 514,822.9       | 25,195.4          | 105.1 |
| 3 | <b>Нийт ашиг (алдагдал)</b>                  | <b>10,860.4</b>    | <b>104,072.5</b> | <b>83,872.8</b> | <b>(20,199.7)</b> | 80.6  |
| 4 | Ерөнхий ба удирдлагын зардал                 | 72,570.5           | 62,372.5         | 52,812.7        | (9,559.8)         |       |
| 5 | Бусад зардал                                 | 11,078.0           | 30,200.0         | <b>19,009.0</b> | (11,191.0)        |       |
| 6 | <b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b> | <b>(72,788.1)</b>  | <b>11,500.0</b>  | <b>12,051.1</b> | <b>551.1</b>      | 104.8 |
| 7 | Орлогын татварын зардал                      | -                  |                  | 1,205.1         |                   |       |
| 8 | <b>Татвар дараах ашиг (алдагдал)</b>         | <b>(72,788.1)</b>  | <b>11,500.0</b>  | <b>10,846.0</b> | <b>551.1</b>      | 94.3  |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад татвар болон нийгмийн даатгалын байгууллагатай өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн Ахлах аудитор Э.Батчимэг, аудитор Ч.Батсэрээдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Г.Энхтөр хэрэгжүүлсэн.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн. Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын бүтэц зохион байгуулалтад дотоод аудитын нэгж, ажилтан байхгүй байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 695.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 7.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын зорилго нь төр, засгийн байгууллагад олон улсын стандартын түвшинд хүрсэн хэвлэлийн бүтээгдэхүүний бүх төрлийн үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.Үүнд:

- Хууль тогтоомж, Засгийн газрын нийтлэг үйлчилгээний бодлогын хүрээнд үйлчлүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах хэвлэлийн бүх төрлийн үйлчилгээг холбогдох шийдвэр, гэрээ, захиалгын дагуу батлагдсан зардал, норм, стандартын дагуу эрхлэн зохион байгуулж, биелэлтийг хангана.
- Төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалттай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Хариуцсан ажлын чиглэлээр дотоодын болон гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжтэй холбоо тогтоож, хамтран ажиллах, эрхлэх ажлын хүрээнд хяналт-шинжилгээ, судалгаа хийнэ.
- Чиг үүргийн хүрээнд гадаад худалдааны үйл ажиллагаа эрхэлнэ.
- Хэвлэлийн үйлчилгээний мэргэшсэн ажилтан бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд тухайн байгууллага нь төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар эзэмшиж байна.

### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ нь 1968 оны 7 дугаар сарын 19-ний өдөр анх үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 125 тоот тушаалаар ТӨҮГ-ын дүрмийг шинэчлэн баталсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна. Тус ТӨҮГ-нь ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг томилоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон

өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд жил бүр хөрөнгийн тооллого хийх комиссыг томилон ажлын үр дүнг хэлэлцэж шийдвэрлэн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу хэмнэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | /мянган төгрөг/    |
|---|------------------|------------------|--------------------|
|   |                  |                  | Өөрчлөлт           |
| Б   | 1                | 2                | 3=2-1              |
| Мөнгөн хөрөнгө                                    | 242,648.90       | 285,882.50       | 43,233.6           |
| Авлага  | 27,209.8         | 31,071.1         | 3,861.3            |
| Бараа материал                                    | 47,584.9         | 75,890.3         | 28,305.4           |
| Үндсэн хөрөнгө                                    | 392,202.8        | 120,409.4        | (271,793.4)        |
| Биет бус хөрөнгө                                  | 32,832.5         | 18,040.5         | (14,792.0)         |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>742,478.9</b> | <b>531,293.8</b> | <b>(211,185.1)</b> |
| Богино хугацаат өглөг                             | 19,525.3         | 19,807.4         | 282.1              |
| Эздийн өмч  | 722,953.6        | 511,486.4        | (211,467.2)        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>742,478.9</b> | <b>531,293.8</b> | <b>(211,185.1)</b> |

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 0.1 сая төгрөг, банкны харилцах дансанд байгаа 285.8 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд харилцагч байгууллагаас авах авлага 31.1 сая төгрөг байна.

Тайлант онд хэвлэлийн бүтээгдэхүүний борлуулалтын хүрээнд үүссэн Төрийн албаны зөвлөлөөс авах авлага 5.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 75.9 сая төгрөг болж 28.3 сая төгрөгөөр өссөн нь түүхий эд материалын үнийн өсөлтөөс шалтгаалжээ.

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэлд үнэ төлбөргүй хүлээн авсан болон ашиглалтгүй хөрөнгө байхгүй байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө данс худалдан авсан 2.2 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант үеийн элэгдлийн зардал 62.8 сая төгрөг болон хуримтлагдсан элэгдлийн залруулга 211.2 сая төгрөгөөр буурсан байна.

Биет бус хөрөнгө 14.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн элэгдлийн зардал 3.7 сая төгрөг болон 11.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн залруулга хийснээс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд байгууллагад өгөх өглөг 1.6 сая төгрөг, ААНОАТ-ын өглөг 1.2 сая төгрөг, НӨАТ-ын өглөг 5.1 сая төгрөг, урьдчилж орсон орлого 11.9 сая төгрөгийн өр төлбөр байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран зардал гэж хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад борлуулсан бүтээгдэхүүний өртөг 84.5 сая төгрөгөөр буурсан нь борлуулалтын хэмжээ буурснаас шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт шууд хөдөлмөрийн зардал, шууд материалын зардал, үйлдвэрийн нэмэгдэл зардлуудыг хамруулсан байна. Үүнээс үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хуваарилагдахгүй зардлууд байхгүй байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөө, нийт бүтээгдэхүүний төлөвлөгөөг баталж 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 100 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Тайлант оны нийт орлогыг 593.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 582.2 сая төгрөгөөр, 11.5 сая төгрөгийн ашиг байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 598.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 586.6 сая төгрөгийн зардал гарган, 12.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 598.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 5.0 сая төгрөг буюу 0.8 хувиар давсан 12 дугаар сард захиалгын хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 586.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 4.4 сая төгрөг буюу 0.7 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь захиалгын хэмжээ нэмэгдэж, түүхий эд материалын зардал нэмэгдсэнээс гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 12.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 0.6 сая төгрөгөөр илүү байгаа нь 12 дугаар сарын борлуулалт нэмэгдсэн нь нөлөөлж байна.

#### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

## 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ нь тайлант онд нийт 376.5 сая төгрөгийн 79 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 7.9 сая төгрөгийн 9 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 61.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 53.2 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 8.5 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |          | Биелэлт |          | Зөрүү |     |      |
|-----------------|---------------------|----------|---------|----------|-------|-----|------|
|                 | Тоо                 | Дүн      | Тоо     | Дүн      | Тоо   | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1                   | 70,778.7 | 1       | 70,778.7 | -     | -   | 100  |
| Зөвлөмж         | 2                   | -        | 2       | -        | -     | -   | 100  |
| Нийт дүн        | 3                   | 70,778.7 | 3       | 70,778.7 | -     | -   |      |

/мянган төгрөг/

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 226.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 222.3 сая төгрөгийн алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 3.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 4.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 7.0 сая төгрөгийн түвшинээс 3.0 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой биет болон биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдлын тооцооллыг давтан шалгахад элэгдлийн зардлыг 222.3 сая төгрөгөөр дутуу тооцоолсныг залруулсан.



## 8.2 Төлбөрийн акт

2021 оны 8 дугаар сарын 26-нд тушаал шийдвэр болон анхан шатны баримтын бүрдэл дутуу илүү цагийн хөлс 0.09 сая төгрөг олгосон байна.

Энэ нь эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Ажилчдад олгосон урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тэтгэмж тусламжийн орлогоос 0.2 сая төгрөгийн ХХОАТ-ын тооцоог хийгээгүй, харьяалах татварын байгууллагад төлөөгүй, тайлагнаагүй байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

## 8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. *НДШ-тэй холбоотой асуудал*

Илрүүлэлт:

Тайлант хугацааны цалингийн тооцооллыг НДШ төлөлтийн тайлантай тулган шалгахад 0.7 сая төгрөгийн цалин хөлсийг дутуу тайлагнаж 0.2 сая төгрөгийн НДШ-ийн тооцоог дутуу хийсэн байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/182 тоот тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, хүлээн авах, хянах, баталгаажуулах журам"-ын 3.1.1 "Ажил олгогч нь даатгуулагчид олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг үнэн зөв тодорхойлох" заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

НДШ-ийн ногдуулалт хийхдээ дээрх хууль, журмыг баримтлах, НДШ төлөлтийн тайланг үнэн зөв тайлагнаж тооцоог хийх, тайлант хугацааны эцэст НД-ын байгууллагатай хийх өглөг, авлагын тооцоог тулган баталгаажуулж ажиллах.

### 2. *ХХОАТ-тай холбоотой асуудал*

Илрүүлэлт:

Цахим татварын системд ХХОАТ-ын авлага 3.5 сая төгрөг, НӨАТ-ын өглөг 0.007 сая төгрөг байгаа боловч санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.10 "Татвар төлөгч нь хууль тогтоомж болон татварын албанаас баталсан заавар, аргачлал, маягт, дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй" гэж заасныг зөрчсөн байна.



Өгсөн зөвлөмж:

Суутган тооцсон ХХОАТ-ын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх, тайлант хугацааны эцэст харьяа татварын байгууллагатай хийх өглөг, авлагын тооцоог тулган баталгаажуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| д/д                             | Байгууллагын нэр              | Аудитын код            | Алдаа зөрчлийн утга  | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга   | Нийт алдаа, зөрчлийн дүн |         | /мянган төгрөгөөр/ |     |     |       |                        |     |                   |     |         |     |
|---------------------------------|-------------------------------|------------------------|--|--|--------------------------|---------|--------------------|-----|-----|-------|------------------------|-----|-------------------|-----|---------|-----|
|                                 |                               |                        |  |  |                          |         | Залруулга          |     | Акт |       | Үүнээс Албан шаардлага |     | Хариуцлага тооцох |     | Зөвлөмж |     |
|                                 |                               |                        |  |  | Тоо                      | Дүн     | Тоо                | Дүн | Тоо | Дүн   | Тоо                    | Дүн | Тоо               | Дүн | Тоо     | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар |                               |                        |  |  |                          |         |                    |     |     |       |                        |     |                   |     |         |     |
| 2                               | Засгийн газрын хэвлэх үйлдвэр | АХГ-2022/31/НА-СТА-ТӨА | 2021 оны 8-р сарын 26-нд тушаал шийдвэр болон анхан шатны баримтын бүрдэл дутуу илүү цагийн хөлс 91.6 мянган төгрөг олгосон байна,   | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн  | 1                        | 91.7    |                    |     | 1   | 91.7  |                        |     |                   |     |         |     |
| 2                               | Засгийн газрын хэвлэх үйлдвэр | АХГ-2022/31/НА-СТА-ТӨА | Ажилчдад олгосон урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тэтгэмж тусламжийн орлогоос 240.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын тооцоог хийгээгүй, харьяалах татварын байгууллагад төлөөгүй, тайлагнаагүй байна. | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25-р зүйлийн 25.1.1 "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" заалтыг зөрчсөн | 1                        | 240.0   |                    |     | 1   | 240.0 |                        |     |                   |     |         |     |
| 3                               | Засгийн газрын хэвлэх үйлдвэр | АХГ-2022/31/НА-СТА-ТӨА | Тайлант хугацааны цалингийн тооцооллыг НДШ төлөлтийн тайлантай тулган шалгахад 675.4 мянган төгрөгийн цалин хөлсийг дутуу тайлагнаж 182.4 мянган төгрөгийн НДШ-н тооцоог дутуу хийсэн байна.   | Нийгмийн даатгалын тухай хуулийн 17-р зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх"  | 1                        | 182.4   |                    |     |     |       |                        |     |                   | 1   | 182.4   |     |
| 4                               | Засгийн газрын хэвлэх үйлдвэр | АХГ-2022/31/НА-СТА-ТӨА | Цахим татварын системд ХХОАТ-ын авлага 3,460.7 мянган төгрөг, НӨАТ-ын  | Татварын ерөнхий хуулийн 28-р зүйлийн 28.10 "Татвар төлөгч нь  | 1                        | 3,468.1 |                    |     |     |       |                        |     |                   | 1   | 3,468.1 |     |

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|   |                               |                        |  |   |   |           |   |           |   |       |   |         |   |         |  |  |   |         |
|---|-------------------------------|------------------------|--|---|---|-----------|---|-----------|---|-------|---|---------|---|---------|--|--|---|---------|
|   |                               |                        | өглөг 7.4 мянган төгрөг байгаа боловч санхүүгийн тайланд тусгаагүй байна   | хууль тогтоомж болон татварын албанаас баталсан заавар, аргачлал, маягт, дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй",  |   |           |   |           |   |       |   |         |   |         |  |  |   |         |
| 5   | Засгийн газрын хэвлэх үйлдвэр | АХГ-2022/31/НА-СТА-ТӨА | Биет болон биет бус хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг давтан тооцоолоход санхүүгийн тайлантай 222,313.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.     | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" | 1 | 222,313.3 | 1 | 222,313.3 |   |       |   |         |   |         |  |  |   |         |
| <b>ДҮН</b>  |                               |                        |  |   | 5 | 226,295.5 | 1 | 222,313.3 | 2 | 331.7 |   |         |   |         |  |  | 2 | 3,650.5 |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал |                               |                        |  |   |   |           |   |           |   |       |   |         |   |         |  |  |   |         |
| 1   | Засгийн газрын хэвлэх үйлдвэр | АХГ-2022/31/НА-СТА-ТӨА | Тайлант хугацаанд 7,906.0 мянган төгрөгийн дүн бүхий 9 мэдээллийг мэдээлээгүй байна. Шилэн дансны нийт мэдээллийн дундаж хувь 82 хувь байна. | Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ"  | 1 | 7,906.0   |   |           |   |       |   |         | 1 | 7,906.0 |  |  |   |         |
| <b>ДҮН</b>  |                               |                        |  |   | 1 | 7,906.0   |   |           |   |       |   |         | 1 | 7,906.0 |  |  |   |         |
| <b>НИЙТ ДҮН</b>   |                               |                        |  |   | 6 | 234,201.5 | 1 | 222,313.3 | 2 | 331.7 | 1 | 7,906.0 |   |         |  |  | 2 | 3,650.5 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 09 дугаар сарын 15 № 66/А-100054  
441-2022/31/НН-СГА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилчдад олгосон урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тэтгэмж тусламжийн орлогоос 240,000.00 төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй, харьяалах татварын байгууллагад төлөөгүй, тайлагнаагүй байна.


Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хувь хүний орлогын албан татварт 240,000.0 төгрөгийг суутган тооцож Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын дарга Б.Отгонбаяр, нягтлан бодогч Т.Оюунсүвд нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
Г.ЭНХТӨР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 08 дугаар сарын 15 № 65 / 150057  
АТГ - 2022.08.15 / НТ - 008 - 70А  
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тушаал шийдвэр болон анхан шатны баримтгүйгээр нэр бүхий 2 ажилтанд илүү цагийн хөлс 91,685.00 төгрөг олгосон байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.3.1 "анхан шатны баримт бүрдүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий хоёр ажилтанд анхан шатны баримтгүйгээр олгосон 91,685.0 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын дарга Б.Отгонбаяр, нягтлан бодогч Т.Оюунсүвд нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
Г.ЭНХТӨР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 дугаар сарын 15

№ 845/4150054

Улаанбаатар хот

АХТ - 2022/31/МН - СЯВ - 708

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Шилэн дансны цахим мэдээллийн санд 7,906,000.00 төгрөгийн дүн бүхий ажил, гүйлгээний 9 мэдээллийг байршуулаагүй байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг үнэн зөв, иж бүрэн байршуулах, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын дарга Б.Отгонбаяр, нягтлан бодогч Т.Оюунсүвд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА

Г.ЭНХТӨР



## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing a summary.



